



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 1/286

Ховд


Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5/07 дугаар "Аймгийн 2022 оны төсөв батлах тухай" тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд Амарсанаагийн цэцэрлэгт хүрээлэн, Баруун бүсийн цагдаагийн сургалтын төвийг ойжуулах мод (улиас, хайлаас, бургас) худалдаж авах, тариалах, арчилж хамгаалах арга хэмжээнд 5,000,000 төгрөг (таван сая)-ийн худалдан авах ажиллагаа зохион байгуулах, гэрээ байгуулах, тайлагнах эрхийг Цагдаагийн газрын дарга (Д.Мөнхболд)-д шилжүүлсүгэй.

2. Дээрх зардалд зарцуулагдах 5,000,000 төгрөг (таван сая)-ийг аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний 3.1-д тусгагдсан Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд 20,0 сая мод хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Жаргалсайхан)-д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 1480